



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 10 сарын 04-ны өдөр

Дугаар A/89

Эрдэнэ

Г Эрүүл мэндийн байгууллагууд өндөржүүлсэн  
бэлэн байдлын зэрэгт шилжин  
ажиллах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1, 10.4.2, 10.5, 51 дүгээр зүйлийн 51.1, хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1 дэх, Аймгийн Засаг даргын 2022 оны 10-р сарын 02-ны A/680 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулахтай холбогдуулан 2022 оны 10-р сарын 02-ны өдрөөс 10-р сарын 08-ны өдрийг дуустал эрүүл мэндийн байгууллагууд өндөржүүлсэн бэлэн байдалд ажилласугай.
2. Газар хөдлөлтийн үеийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг үзүүлэх "Хээрийн эмнэлэг" дэлгэх бэлтгэл, бэлэн байдлыг хангуулан, дадлага сургуулилтад оролцохыг БОЭТ-ийн захирал /Ц.Наран-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.
3. Нүүлгэн шилжүүлэлтийн үеийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг тухай харьяаны Өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгүүд хариуцан бэлтгэл бэлэн байдлыг ханган оролцохыг Өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн дарга нарт даалгасугай.
4. Эрүүл мэндийн албаны штабын байр болон шуурхай удирдлагын төвд 24 цагийн жижүүр /холбоочин/-ийн үүрэг гүйцэтгэх албан хаагч нарыг томилгоожуулан ажиллуулахыг Яаралтай гамшигийн үеийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Уртнасан/-дааалгасугай.
5. Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтын бэлэн байдлыг хангуулах, үүрэгжүүлэх, мэргэжлийн анги, багуудад дэмжлэг үзүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн албаны орлогч дарга, гишүүдэд даалгасугай.

6. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн иргэдийн сэтгэл зүй, иргэд рүү хандсан сургалт, сурталчилгааг эрчимжүүлж ажиллахыг Сэтгэл зүйн тусlamж үйлчилгээ хариуцсан ажилтан /Г.Будмаа/, эрүүл мэндийн мэдээлэл сургалт, сурталчилгаа, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн /А.Ганчимэг/ нарт үүрэг болгосугай.

7. Эрүүл мэндийн албаны штабын байрыг техник, тоног төхөөрөмж, эд хогшил, хүнс, бичиг хэргийн материалаар хангах, зарлан мэдээллийг дамжуулан ажиллахыг Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, байгууллагуудын үйл ажиллагааны автоматжуулалт, сүлжээ хариуцсан мэргэжилтэн /Х.Оюун-Эрдэнэ/, нярав /Б.Алтанзагас/ нарт үүрэг болгосугай.

8. Эрүүл мэндийн байгууллагууд гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулилтад шаардагдах төсвийг байгууллагын төсөвтөө багтаан шийдвэрлэж, илүү цагийн нэмэгдэл хөлсийг хөдөлмөрийн тухай хуулинд зааснаар олгохыг байгууллагуудын захирал, дарга нарт үүрэг болгосугай.

9. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Яаралтай гамшгийн үеийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Уртнасан/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.СҮХЭЭ